



ҮАГ-ЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төр, төсвийн
байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаа

Ерөнхий дүгнэлт:

Хүдэр сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа туйлын хангалтгүйгээс төр, төсвийн байгууллагуудад цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулах, тайлагнагдаагүй өр төлбөр барагдуулах, цалингийн сангийн хэмнэлтээс урамшуулал давхардуулан олгох, шатахуун, бичиг хэргийн зардлыг ажилтнуудын дансанд шилжүүлэх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчил их хэмжээгээр оршиж байна.

Сүхбаатар сум 2015 он

Тайланг бэлтгэсэн:

**Сэлэнгэ аймгийн
Аудитын газар**

Дарга, Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа
Аудитын менежер
Б.Батмөнх

Аудитор Ц.Отгонбаяр
Шинжээч С.Баасансүрэн
Э.Эрдэнэзул
А.Дашбат

2015 оны 09 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70363036 дугаарын утсаар
харилцана уу

ХАЯГ:

Сэлэнгэ аймаг
Сүхбаатар хот
Аймгийн ЗДТГ-ын
өргөтгөлийн 2-р давхар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4

Бүлэг 1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?

Бүлэг 2. Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл

Бүлэг 3. Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагын санал:

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
СЭАГ	Сэлэнгэ аймгийн Аудитын газар
ЭА	Эрсдэлийн аудит
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НД	Нийгмийн даатгал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
БСГ	Боловсрол, Соёлын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СХС	Сум хөгжүүлэх сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудит

2. Аудитын код:

СЭАГ-2015/03-ЭА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын 2013, 2014 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим эрсдэлтэй асуудлыг сонгон шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад эрсдэлийн аудитын зорилт чиглэгдсэн болно. Эрсдэлийн аудитыг 3 дэд асуудлаар шалган гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?
2. Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл
3. Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

5. Аудитын хамрах хүрээ:

Хүдэр сумын ИТХ, ЗДТГ, Баг, Сургууль, Цэцэрлэг, ЭМТ, Ойн анги, тусгай сангуудын 2013, 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд байгууллагуудын НББ-ийн анхан шатны баримт, санхүүгийн тайлан баланс болон холбогдох бусад баримт материал, мэдээллийн эх сурвалжуудыг хамруулан шалгалаа.

6. Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын гарын авлага, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Хүдэр сумын ТЭЗ, Төрийн сангийн төлөөлөгч, төсвийн байгууллагуудын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, төр, төсвийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, нотлох зүйлийг ашиглан түүнд судалгаа, шинжилгээ хийх, давтан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа.

Аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

7. Үндсэн мэдээлэл

Хүдэр сумын төсвийн орлогыг 2013 онд 168862,4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 173829,3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бол 2014 онд 310111,1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 382692,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Сумын хэмжээгээр урсгал санхүүжилт 100 хувь олгогдсон бөгөөд орон нутгийн төсөвт байгууллагууд 499844,7 мянган төгрөгийн, тусгай шилжүүлгийн байгууллагууд 1162013,4 мянган төгрөгийн зарлага гарган ажиллажээ. Урсгал санхүүжилтийн 48,4 хувийг цалин хөлс, 4,5 хувийг тогтмол зардалд, 7,6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 39,5 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн хэмнэлтээс 3446,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр төсвийн гүйцэтгэл 93.2 хувьтай тайлагнагджээ.

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2013 онд 264027,7 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 16786,7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 247241,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр, 2014 онд 313000,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн ч 88550,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 224450,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тус тус тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх санд 2013 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 80000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн хүүгийн орлогын 3085,3 мянган төгрөгийн нийт 83085,3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 76000,0 мянган төгрөгийн зээлийг, 2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 18000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтийн 18115,5 мянган төгрөгийн нийт 36115,5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 34000,0 мянган төгрөгийн зээлийг олгожээ.

Тус сумын Ойн ангийн 2013 оны санхүүгийн баримт материалыг олдохгүй байна / нягтлан бодогчоор ажиллаж байсан Эрдэнэцэцэг баримтыг алга болгосон / гэсэн шалтгаанаар эрсдэлийн аудитын явцад үзүүлээгүй болно.

БҮЛЭГ 1.Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу

1.1. Цалин, НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан эсэх

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын цалин, НДШ-ийн зардлын төлөвлөлтийг гүйцэтгэлтэй тулган шалгах гэсэн боловч тайлант онуудын төсвийн төслүүд огт байхгүй байлаа. Иймээс цаашид төсвийн төслийг албан ёсоор баталгаажуулж, баталгаажсан нэг хувийг санхүүгийн баримтанд хавсаргаж байх шаардлагатай байна.

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын цалин, НДШ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэрс	Зардлын нэр	2013 он		2014 он	
			Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	ЗДТГ	Цалин	138912,2	138912,2	154429,6	154429,6
		НДШ	12985,6	12985,6	16630,8	16630,8
2	ИТХ	Цалин	27088,1	27074,1	29855,3	28904,9
		НДШ	2979,7	2835,1	3172,2	2949,7
3	Баг	Цалин	14380,1	14463,6	15571,2	15571,2
		НДШ	1581,8	1415,0	1713,4	1713,4
4	ЭМТ	Цалин	118603,2	118603,2	133032,8	129477,4
		НДШ	14288,1	13467,0	14401,2	14401,2
5	Сургууль	Цалин	318731,0	318731,0	382015,4	382015,4
		НДШ	34124,3	34124,3	41703,8	41703,8
6	Цэцэрлэг	Цалин	128477,2	128477,2	157582,2	157582,2
		НДШ	15667,1	15562,8	15615,9	15615,9
7	Ой анги	Цалин			17865,0	18537,9
		НДШ			1965,1	2231,9

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын 2013, 2014 оны цалингийн сангийн зарцуулалтыг цалингийн баримт, цагийн бүртгэл, холбогдох тушаал шийдвэртэй нь тулган баталгаажуулахад цалингийн сангийн хэмнэлтийг эмч, сувилагч нарт ажлын үр дүнг харгалзахгүйгээр, нэмэгдэл хэлбэрээр хавтгайруулан олгох, багш ажиллагсдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нэмэгдэл цалин олгох, цалингийн урьдчилгааг дутуу суутгах, цалингийн зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнахгүй байх зэрэг зөрчлүүд их хэмжээгээр оршиж байгаа нь дараах хууль, журмыг зөрчсөн байна. Тухайлбал: МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1¹, 16.5.5², МУ-ын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын заалтуудыг зөрчиж:

- ❖ ИТХ нь төлөөлөгчдийг Улаанбаатар хотод “Нутгийн удирдлагын холбоо”-ны сургалтанд хамруулан 2013 онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 4022,1 мянган төгрөгийг, 2014 онд төлбөр хураамжийн зардлаас 5000,0 мянган төгрөг зарцуулсан,
- ❖ ИТХ-ын дарга Р.Цогбадрах нь 2013 онд “Үр дүнгийн болон нэмэгдэл урамшуулал олгох тухай” 14 тоот захирамж гарган өөртөө 150,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,

¹ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

- ❖ Багийн Засаг дарга Ц.Цэнбумаа нь 2014 онд “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” 05 тоот захирамж гарган өөртөө болон 2-р багийн Засаг дарга Т.Эрдэнэбатад нийт 300,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,
- ❖ Сургууль нь улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2013 онд 923,7 мянган төгрөгийн, 2014 онд 1601,2 мянган төгрөгийн зэрэг нийт 2524,9 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг багш, ажиллагсдад олгосон,
- ❖ Сургууль нь 2013 онд төсөвт сууж батлагдаагүй бүжгийн багшийг гэрээгээр 1 сарын хугацаатай ажиллуулан 502,2 мянган төгрөгийн цалин олгосон,
- ❖ Цэцэрлэг нь 2014 онд улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 722.5 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.8³, 41.2.2⁴, 41.2.3⁵, НББ-ийн тухай хуулийн 7.1⁶, Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.1.5⁷ дахь заалтуудыг зөрчиж :

- ❖ ЗДТГ нь 2013 онд цалингийн зардлаас үр дүнгийн урамшуулалд 658,6 мянган төгрөг, шатахууны зардалд 891,8 мянган төгрөг зэрэг нийт 1550,4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ ЗДТГ нь 2014 онд цалингийн зардлаас урьд оны ХХОАТ-ын өр төлбөрт 4411,1 мянган төгрөг, НД-ын байгууллагаас тогтоосон актын төлбөрт 801,1 мянган төгрөг, ажилтан Цэнгэлмаа, Энхбаяр нарын сургалтын төлбөрт 533,0 мянган төгрөг нийт 5745,2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ 2013 онд эд хогшлын зардлаас багийн дарга Ц.Цэнбумаагийн томилолтын зардалд 16,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ ЭМТ нь 2014 онд цалингийн зардлаас эмийн зардалд 1286,9 мянган төгрөгийг, магадлан итгэмжлэлийн төлбөрт 450,0 мянган төгрөгийг нийт 1736,9 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ Цэцэрлэг нь 2014 онд үндсэн цалингаас 3927.6 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулалд гүйлгэн зарцуулсан,
- ❖ Цэцэрлэг нь 2014 онд цалингийн зардлаас урьд оны НДШ-ийн өр төлбөрт 4175,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ Сургууль нь 2014 онд НДШ-ийн зардлаас 1019,4 мянган төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулсан,
- ❖ Сургууль нь 2013 онд жижүүр Ж.Энхдалайд цалингийн урьдчилгаанд олгосон 260,0 мянган төгрөгийг буцаан суутгаагүй байна.

³ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

⁴ Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

⁵ Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁶ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно

⁷ Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон хойшлогдсон эсвэл зарцуулагдаагүй нэг удаагийн арга хэмжээний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулахгүй байх

ЭМТ нь 2003 оны Эрүүл мэндийн сайд, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайд, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан 233/141/310 тоот тушаалын 2.2⁸, 2.3⁹ дахь, ЗГ-ын 2012 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.10¹⁰ дахь заалтуудыг зөрчиж:

- ❖ Эмч, сувилагч нарт тушаал шийдвэргүйгээр сар бүр 10 хувиар тооцож, ур чадварын нэмэгдэлд 2013 онд 4246,0 мянган төгрөг, 2014 онд 2017,7 мянган төгрөг зэрэг нийт 6263,7 мянган төгрөг олгосон,
- ❖ Тушаал, шийдвэр, дэмжих баримтгүйгээр эмч, сувилагч нарт хүнд өвчтөн асарсан, сургалт зохион байгуулсан зэрэг шалтгаанаар сар бүр 10 хувийн нэмэгдлийг хавтгайруулан олгоход 2013 онд 3885,0 мянган төгрөг, 2014 онд 3307,6 мянган төгрөг зэрэг нийт 7192,6 мянган төгрөг зарцуулсан, / **акт** /
- ❖ Эрхлэгч Г.Нармандах нь сумын Засаг даргаар ажлаа дүгнүүлэлгүйгээр, өөрөө өөртөө тушаал гарган тайлант онуудад 1514,2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
- ❖ Нягтлан бодогч, нярав, жижүүр, слесарь зэрэг 5 хүний үр дүнгийн урамшууллыг 2013 онд 868,5 мянган төгрөгөөр, 2014 онд 1090,0 мянган төгрөгөөр зэрэг нийт 1958,5 мянган төгрөгөөр дутуу олгосон,
- ❖ Эрсдлийн аудитын явцад цалингаас суутгасан ХХОАТ-ыг татварын тайлантай тулган баталгаажуулахад цалингийн санг 9927,4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж, 666,8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Дээрх алдаа зөрчлөөс гадна ЭМТ-ийн нягтлан бодогч Ж.Эрдэнэчимэг нь 2014 оны 10-р сард ажилд ороод 10-р сарын 22-нд бага эмч Мөнхтуулын амралтын цалин нэрээр өөрийнхөө Төрийн банкин дахь дансанд 800,0 мянган төгрөг, 10-р сарын 31-нд сувилагч Сарангэрэлийн цалин нэрээр Д.Эрдэнэбатын / Ж.Эрдэнэчимэгийн нөхөр нь гэх/ Төрийн банкин дахь дансанд 350,0 мянган төгрөг, 11-р сард цалингийн цэсний гарт олгох дүнг нэмэгдүүлж өөрийнхөө Хаан болон Төрийн банкны дансанд 508,6 мянган төгрөг зэрэг нийт 1658,6 мянган төгрөгийг хуурамч баримт бүрдүүлэн авч ашигласан байна. / **акт** /

Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 20.1.1¹¹, 20.1.4¹² дэх заалтууд, бүртгэл, тооцооны ажилтны ёс зүйг зөрчсөн тул үүрэгт ажлаас халах хүртэл арга хэмжээ авч, төсөвт учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай.

⁸ Ажлын бус цагаар өмөн үү, амьсгал, зүрх, судас, бөөрний архаг дутагдалтай хяналтын хүнд өвчтөнг сард 5-аас доошгүй удаа гэрээр үзэж, зөвлөгөө өгсөн, сувилгаа үзүүлсэн сум (тосгоны), сум дундын эмнэлгийн эмч, сувилагчид үзлэгийн тооноос хамааруулан 5 хувь хүртэл

⁹ Ажлын байран дахь тасралтгүй сургалтыг сард 3-аас доошгүй удаа, иргэд үйлчлүүлэгчдэд эрүүл аж төрөх талаар сургалтыг сард 5-аас доошгүй удаа тусгай хөтөлбөрөөр явуулсан эмнэлгийн мэргэжилтэнд сар бүр 5 хувь хүртэл

¹⁰ Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэрлэнэ.

¹¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нь албан тушаалаа урвуулан ашиглах

¹² Хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих

Цэцэрлэг нь МУ-ын Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам”-ын 2.5¹³ дахь заалтыг зөрчиж:

- ❖ Эрхлэгч Д.Баярдэлгэр нь аймгийн Засаг даргаар ажлаа дүгнүүлэлгүйгээр 607.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан,
- ❖ Журмын дагуу улирлын үр дүнгийн урамшуулал 45 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтыг зөрчин хавсралт /1/-д дурдсан ажилтнуудад 603,4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү олгосон, / **акт** /

Дээрх байдлуудаас дүгнэхэд Хүдэр сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа туйлын хангалтгүйгээс төр, төсвийн байгууллагууд нь цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулах, тайлагнагдаагүй өр төлбөр барагдуулах, цалингийн сангийн хэмнэлтийг эмч, сувилагч нарт ажлын үр дүнг харгалзахгүйгээр, нэмэгдэл цалин хэлбэрээр хавтгайруулан олгох, боловсролын байгууллагын багш, ажиллагсдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нэмэгдэл цалин олгох зэргээр батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй, үрэлгэн зарцуулдаг зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.

Иймээс цаашид төрийн сангийн хяналтын үйл ажиллагааг холбогдох хууль, заавар, журмын дагуу гүйцэтгэж дээр дурдсан зөрчлүүдийг нэн даруй арилгах, аудитын байгууллагын удаа дараагийн шалгалтаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

1.2. Тогтмол зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан эсэх

Хүдэр сумын ЭМТ-өөс бусад төр, төсвийн байгууллагуудыг “Хүдэр дулаан” ОНӨААТҮГ дулаан, цэвэр усаар хангадаг бөгөөд нэхэмжлэлийн дагуу төлбөрийг шилжүүлж, улирал тутам тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ирсэн байна. Тус сумын төр, төсвийн байгууллагуудын тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэрс	Зардлын нэр	2013 он		2014 он	
			Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	ЗДТГ	Түлш халаалт	12988,6	12988,6	20600,5	20600,5
		Гэрэл цахилгаан	1798,6	1798,6	2674,4	2674,4
		Цэвэр бохир ус	1440,0	1440,0	1340,0	1340,0
2	ЭМТ	Түлш халаалт	7561,6	7474,2	16166,8	16106,9
		Гэрэл цахилгаан	1516,5	1516,5	2614,0	2614,0

¹³ Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд үр дүнгийн урамшил олгох эсэх асуудлыг тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан холбогдох үнэлгээг харгалзан шийдвэрлэнэ

		Цэвэр бохир ус	675,0	762,4	675,0	718,0
3	Сургууль	Түлш халаалт	91315,3	91315,3	100694,0	100694,0
		Гэрэл цахилгаан	3974,6	3974,6	5329,6	5329,6
		Цэвэр бохир ус	1550,0	1550,0	1760,0	1760,0
4	Цэцэрлэг	Түлш халаалт	19965,3	19965,3	21793,0	21792,8
		Гэрэл цахилгаан	1710,0	1710,0	1713,1	1713,3
		Цэвэр бохир ус	1079,2	1079,2	1043,7	1043,7

Сумын төсөвт байгууллагуудын тогтмол зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай нь тулган баталгаажуулахад халаалт, гэрэл цахилгаан, усны төлбөрийг нэхэмжлэхийн дагуу шилжүүлж авлага, өглөг үүсгээгүй боловч МУ-ын Төсвийн тухай хуулийн 16.5.5¹⁴, 41.2.3¹⁵, НББ-ийн тухай хуулийн 7.1¹⁶, 9.1¹⁷, Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 191-р тушаалын 6.3¹⁸ дахь дэх заалтуудыг зөрчсөн дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- ЗДТГ нь 2013 онд халаалтын зардлаас 123,0 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны зардлаас 91,0 мянган төгрөгийн засварын, цэвэр бохир усны зардлаас 120,0 мянган төгрөгийн цэвэрлэгээний материалыг худалдан авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна,
- ЗДТГ нь 2014 онд гэрэл цахилгааны зардлаас халаалтын зардалд 404,1 мянган төгрөгийг, цэвэр бохир усны зардлаас гэрэл цахилгааны зардалд 224,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гэрэл цахилгааны зардлаас 110,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Сургууль нь 2014 онд онд гэрэл, цахилгааны зардлаас халаалтын зардалд 64,5 мянган төгрөгийг, халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 236,1 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.
- ЭМТ нь 2013 онд халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 907,6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Тайлант онуудад ЭМТ нь худалдан авсан түлшний модны тайлан гаргаагүй, өдөр болон сард хэрэглэх норматив тогтоогоогүй, худалдан авсан бөөн дүнгээр зарлагадаж, ямар ч хяналтгүйгээр зарцуулсан байна.

Эрсдлийн аудитын явцад ЭМТ-ийн тайлант онуудын модны зарцуулалтыг харьцуулж үзэхэд 2013 онд 1 машин модыг дунджаар 118,1 мянган төгрөгөөр нийт 40 машин мод худалдан авахад 4724,0 мянган төгрөгийг, хөрөө, уурын зуухны мотор худалдан авахад

¹⁴ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах

¹⁶ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно

¹⁷ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

¹⁸ Бараа материалын бүртгэл

693,5 мянган төгрөгийг, галч нарын цалин болон сантехникийн засварт 2056,7 мянган төгрөгийг зэрэг нийт 7474,2 мянган төгрөгийг, 2014 онд 1 машин модыг дунджаар 148,2 мянган төгрөгөөр, нийт 90 машин мод худалдан авахад 13343,0 мянган төгрөгийг, хөрөөний шатахуун, сантехникийн засвар, галч нарын цалин зэрэгт нийт 2763,9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

ЭМТ-ийн халаах талбайн хэмжээ 2014 онд өмнөх оноос нэмэгдээгүй байхад 2,2 дахин их мод зарцуулсан тооцоо гарсаныг эрхлэгч Г.Нармандахаас тодруулахад “2014 онд өмнөх оноос хүйтэн жил болсон учир мод илүү зарцуулсан, оны эцэст 5 машин модны үлдэгдэлтэй байсан”, мөн аймгийн ЭМГ-ийн мэргэжилтэн У.Ууган-Эрдэнээс тодруулахад “2013 онд аймгийн хэмжээнд сумдын ЭМТ-үүд тогмол зардлын өр төлбөр их үүссэн тул ЭМЯ-нд хүсэлт тавьж, халаалтын зардлын төсвийг нэмж батлуулсан, сумдын ЭМТ-үүдэд төсвийн төслийг үндэслэж хуваарилалтыг хийсэн” гэсэн тайлбаруудыг өгсөн болно. Хэдийгээр дээрх шалтгаанууд байж болох талтай ч түлшний модны худалдан авалт, зарцуулалтад ямар ч хяналт тавигддаггүйгээс батлагдсан төсвийг бүгдийг нь зарж барагдуулах үрэлгэн бодлого баримталж өмнөх оноос даруй 2,2 дахин илүү түлш зарцуулсан байна гэж дүгнэж байна.

ЭМТ нь 2014 оны эцэст 5 машин буюу 741,0 мянган төгрөгийн модны үлдэгдэлтэй байсан гэх боловч балансад үлдэгдлээр тайлагнаагүй байгаа нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 9.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг УСНББОУС-ын дагуу үнэн зөв, иж бүрэн хөтөлж, нормативыг бодитой тогтоож, халаалтын зардалд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дээрх байгууллагууд нь тогтмол зардлыг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусад зардалд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй байгаа нь МУ-ын Төсвийн тухай хууль болон аймгийн Аудитын газраас удаа дараа өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй, сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

1.3 Эм, хоол, үдийн цай, бусад зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх

Хүдэр сумын сургууль, цэцэрлэг, ЭМТ-ийн эм, хоол, үдийн цай, шатахууны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэрс	Зардлын нэр	2013 он		2014 он	
			Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Сургууль	Эм	185,0	185,0	145,9	145,9
		Хоол	14049,9	14049,9	11829,7	11829,7
		Үдийн цай	19572,4	19572,4	18152,5	18152,5
		Шатахуун	3310,0	3310,0	3153,0	3152,9
		Эм	227,0	227,0	87,9	87,9

2	Цэцэрлэг					
		Хоол	34416,1	34489,0	35673,2	35673,2
		Шатахуун	1201,0	1201,0	151,0	151,0
3	ЭМТ	Эм	7609,1	7609,1	7609,1	8896,0
		Хоол	3108,9	3108,9	3976,2	3976,2
		Шатахуун	7215,0	7215,0	7215,0	7215,0
4	ЗДТГ	Шатахуун	8900,0	8867,9	9000,0	9000,0

Сургууль нь 2013 онд дотуур байрны хүүхдийн хоолны материалын 6320,6 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 7728,6 мянган төгрөгийн материалыг орлогод авч, 13345,8 мянган төгрөгийн материалыг зарцуулан оны эцэст 703,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр, 2014 онд 11530,2 мянган төгрөгийн материалыг орлогод авч, 12233,6 мянган төгрөгийн материалыг зарцуулан үлдэгдэлгүйгээр тайлагнагдсан байна.

Тус сургууль нь 2013 онд “Үдийн цай” хөтөлбөрийг иргэн Д.Сарантуяатай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан талаарх баримт материал байхгүй байлаа. Гэрээгээр ажиллуулж байсан иргэн Д.Сарантуяаг 2014 онд үндсэн ажилтан буюу үдийн цайны тогоочоор авч ажиллуулан сургуулийн өөрийн гал тогоогоор дамжуулан гүйцэтгэжээ.

Цэцэрлэг нь 2013 онд хүүхдийн хоолны зардалд 34567,8 мянган төгрөг төлөвлөн гүйцэтгэлээр 34527,7 мянган төгрөг зарцуулан, 40,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан бол 2014 онд 34873,2 мянган төгрөг төлөвлөн, гүйцэтгэлээр 34873,2 мянган төгрөг зарцуулан оны эцэст үлдэгдэлгүйгээр тайлагнасан байна.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг өдөрлөгтэй нь тулган шалгахад нэг хүүхдэд ногдох хоолны нормативт зардлын хэмжээнд багтаан ажилласан байлаа.

ЭМТ нь эм, хоолны зардлыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөсөн боловч 2014 онд эмийн зардал бага батлагдсанаас оны эцэст 1286,9 мянган төгрөгийн өр үүссэн учир сумын төрийн сангийн мэргэжилтний зөвшөөрлийн дагуу цалингийн зардлын хэмнэлтээс гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.1.5¹⁹ дахь заалттай зөрчилдөж байна. Эм, хоолны зардалд зайлшгүй өр үүсвэл хооронд нь гүйлгэн зарцуулах, эсвэл аймгийн ЭМГ-т хандан нэмэлт санхүүжилт хүсэн хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй юм.

Мөн эмийн тайлан гаргаагүй байгаа нь эмийн орлого, зарлагыг тулган баталгаажуулахад хүндрэл учруулсан бөгөөд эмийн дэлгэрэнгүй тайланг сар бүр гаргаж,

¹⁹ Цалин хөлс нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гаргахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж болон хойшлогдсон эсвэл зарцуулагдаагүй 1 удаагийн арга хэмжээний зардлыг бусад зардлын зүйлд шилжүүлэн зарцуулж болохгүй

НББ-ийн тухай хуулийн 9.1²⁰ дахь заалтын дагуу тооллогыг улирал бүр хийж хэвших, зардалд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудын бусад зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад МУ-ын Төсвийн тухай хуулийн 47.1.5²¹, НББ-ийн тухай хуулийн 7.1²², 7.7²³, 11.2.1²⁴, 20.1.2²⁵, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.2²⁶ дахь заалтыг зөрчсөн дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- ❖ Ойн анги нь 2014 онд 50093,2 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэйгөөс 50367,7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнаж, 274,5 мянган төгрөгөөр төсөв хэтрүүлэн зарцуулсан,
- ❖ ЗДТГ нь 2013 онд 9000,0 мянган төгрөгийн, сургууль нь 2013 онд 3310,0 мянган төгрөгийн, 2014 онд 3152,9 мянган төгрөгийн, цэцэрлэг нь 2013 онд 1201,0 мянган төгрөгийн, 2014 онд 150,6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч зарцуулалтын тайлан үйлдээгүй, жолоочийн тооцооны хуудсыг бичүүлээгүй шууд зардлаар бүртгэсэн,
- ❖ 2013 онд ИТХ нь 1011,0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 3882,6 мянган төгрөгийн, багийн Засаг дарга нь 356,1 мянган төгрөгийн шатахууны зардлыг анхан шатны баримтгүйгээр бүртгэл тайланд тусгасан,
- ❖ ИТХ нь тайлант онуудад материалын тайлан гаргаагүй, жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийгээгүй,
- ❖ Ойн ангийн нягтлан бодогч Ш.Урнаа нь 2014 онд нийт 537,0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний хүсэлт бичин өөртөө цохолт хийж авсан,
- ❖ 2013 онд ЗДТГ нь шатахууны зардлаас 345,5 мянган төгрөгийг жолооч А.Хүдэрхуягийн, ИТХ нь урсгал засварын зардлаас 500,0 мянган төгрөгийг дарга Р.Цогбадрахын, шатахууны зардлаас 60,0 мянган төгрөгийг ИТХ-ын төлөөлөгч С.Эрдэнэбатын, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 90,0 мянган төгрөгийг хэсгийн төлөөлөгч Н.Эрдэнэбатын хувийн харилцах дансанд шилжүүлэн зарцуулсан
- ❖ 2014 онд багийн Засаг даргын бичиг хэргийн зардлаас 245,7 мянган төгрөгийг 2-р багийн Засаг дарга Т.Эрдэнэбатын, төлбөр хураамжийн зардлаас 70,0 мянган төгрөгийг 1-р багийн Засаг дарга Ц.Цэнбумаагийн хувийн харилцах дансанд шилжүүлэн зарцуулсан байна.

²⁰ Аж ахуй нэгж, байгууллага эд хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

²¹ 47.1 Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно.47.1.5 төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого

²² Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

²³ Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно

²⁴ Эд хөрөнгийн тооллогыг жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ

²⁵ Нягтлан бодогч нь өөрийн ажил, үүргийн дагуу шууд хяналт тавьдаг албан тушаалын ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно

²⁶ Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ

Сумын зарим төр, төсвийн байгууллагууд нь эм, шатахууны зарцуулалтын тайлан болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Мөн батлагдсан шатахуун, бичиг хэргийн зардлыг хувь хүний дансанд шилжүүлсэн гүйлгээг баталж, гүйцэтгэж байгаа нь сумын төрийн сангийн хяналт хангалтгүй хийгдэж байгааг харуулж байна.

1.4 Тусгай сангийн төлөвлөлт, зарцуулалт

ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт:

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2013 онд 264027,7 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 16786,7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 247241,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Аймгийн Аудитын газраас 2014 онд “Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-нд хийсэн нийцлийн аудитаар тус сумын 2013 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ❖ Хүдэр сумын төвийн болон хорооллуудын дундах зам засварын 67271,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг “Тамирын тод зам” ХХК-иар 2013 оны 10-р сарын 15-ны дотор гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ч гэрээт хугацаанд ашиглалтанд оруулаагүй 2014 оны 05-р сарын 10-ныг хүртэл сунгасан бөгөөд мөн хугацаанд ашиглалтанд оруулаагүй,
- ❖ Хүдэр сумын 1-р багийн Найрамдал, Баянцагаан, 2-р багийн Булагтай хэсгүүдэд 0,4 Квт-ын цахилгааны шугамыг шинэчлэх, трансформатор тавих 80000,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг ашиглалтанд оруулах комиссын актаар хүлээлгэн өгөөгүй, ажил бүрэн дуусаагүй байхад гүйцэтгэгч “Эрчит цэнэг” ХХК-д санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийг аймгийн Аудитын газарт 2014 оны 11-р сарын 25-ны өдөр 1/155 тоотой ирүүлсэн бөгөөд эрсдлийн аудитын явцад газар дээр нь очиж үзэхэд дээрх ажлууд бүрэн дуусч ажил хүлээн авах сумын комиссын актаар хүлээлгэн өгсөн байлаа.

Аймгийн ОНХС-аас тус сумын ОНХС-д 2014 онд 313000,0 мянган төгрөгийг хуваарилахаар төлөвлөсөн боловч 88550,0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, 224450,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Аймгийн Аудитын газраас 2015 оны 5-р сард хийгдсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдал” сэдэвт нийцлийн аудитаар тус сумын ОНХС-гийн 2014 оны зарцуулалтыг газар дээр нь үзэж шалгахад 30000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “1-р багийн гэр хорооллын айл өрхийн 220 Вт-ын гэрлийн шон солих” ажлын захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүйгээс цахилгааны ажлын норм, дүрмийг

зөрчсөн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн билээ. Дээрх ажлыг “Маргад цэц уул” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ажлыг сумын комиссын актаар ашиглалтанд оруулсан ч барилгын норм ба дүрмийг зөрчсөн зөрчлөө арилгаагүй байна.

СХС-ийн төлөвлөлт, зарцуулалт:

Хүдэр сумын СХС-д 2013 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 80000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн хүүгийн орлогын 3085,3 мянган төгрөг зэрэг нийт 83085,3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Тайлант онд төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, Засаг даргын захирамжаар 28 иргэнд 1000,0-5000,0 мянган төгрөг хүртэл хэмжээний нийт 76000,0 мянган төгрөгийн зээлийг жилийн 1.5 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар олгож, үйл ажиллагааны зардалд 7085,3 мянган төгрөгийг зарцуулжээ.

2014 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 18000,0 мянган төгрөгийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтөөс 18115,5 мянган төгрөгийн, нийт 36115,5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, Засаг даргын захирамжаар 5 иргэнд 2000,0-15000,0 мянган төгрөг хүртэл хэмжээтэй нийт 34000,0 мянган төгрөгийн зээлийг жилийн 1.5 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар олгосон байна.

Аймгийн Аудитын газраас 2014 онд хийгдсэн “Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудитаар “Зориулалт бусаар зарцуулсан 4 зээлдэгчийн 12500,0 мянган төгрөгийг, хугацаа хэтрүүлсэн зээлийн 19000,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэх нийт 31500,0 мянган төгрөг”-ийн зөрчилд албан шаардлага өгөгджээ. Эрсдэлийн аудитын явцад албан шаардлагын биелэлттэй танилцахад: Зээлийг зориулалт бусаар зарцуулсан 4 зээлдэгчээс 2 зээлдэгчийн зээлийг, хугацаа хэтэрсэн 19000,0 мянган төгрөгийн зээлээс 4000,0 мянган төгрөгийг төвлөрүүлж бусад зээлийг өнөөдрийг хүртэл барагдуулаагүй байна.

СХС-гийн үйл ажиллагаанд хяналт тавих комиссыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 02-р сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ч хугацаа хэтэрсэн, зориулалт бусаар зарцуулсан зээлийг эргэн төлүүлэх ажил муу хийгдэж, аймгийн Аудитын газраас өгсөн албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна. Иймээс уг сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийг нэн даруй төлүүлэх, холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барьцаа хөрөнгийг гэрээний дагуу борлуулан санг хохиролгүй болгох ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Байгаль хамгаалах сангийн төлөвлөлт, зарцуулалт:

Хүдэр сумын ИТХ-ын 2014 оны 07-р сарын 03-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор “Байгаль хамгаалах сан”-г байгуулж, уг сангийн журмыг хавсралтаар баталсан бөгөөд тайлант оны төсөвт төр, төсвийн байгууллагуудад шаардлагатай хөрөнгө худалдан авах, урсгал засвар хийх зэрэг хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлуудыг тусгасан байна.

Сумын ИТХ-ын 2014 оны 07-р сарын 03-ны өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сан”-гийн төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4 /мянган төгрөг/		
Д/д	Зардлын нэр	Мөнгөн дүн
1	Ойжуулалт, нөхөн сэргээлт, багаж хэрэгсэл	22730,0
2	Нийтийн эзэмшлийн хог цэвэрлэгээ	4949,0
3	Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэцэрлэгжилт	18100,0
4	Наадмын талбайн тохижилт, арчилгаа	2000,0
5	Нохой устгал	1000,0
6	Хогийн цэгийн манаачийн урамшуулал	700,0
7	ЕБС-ын заалны засвар, гадна тохижилт	6560,0
8	Ахмадын байрны гадна талбайн тохижилт	2480,0
9	ЭМТ-ийн гадна тохижилт, цэцэрлэгжилт	6600,0
10	Төв инженерийн шугамын засвар, арчлалт	15403,0
11	Соёлын төвийн гадна тохижилт	2500,0
12	Цэцэрлэгийн гаднах талбайн тохижилт, явган хүний зам	3750,0
13	Сумын авто зам тавихад өмчлөлийн газар чөлөөлсөн нөхөн төлбөр	2500,0
14	Сумын телевизийн сувгийн эрх, тоног төхөөрөмж авах /мэдээлэл сурталчилгаа/	4000,0
15	WIFI-ийн суурь хураамж /мэдээлэл сурталчилгаа/	1400,0
	НИЙТ ДҮН	94672,0

Тайлант онд сангийн хөрөнгийг сумын төсвийн байгууллагуудын тохижилт, цэцэрлэгжилт нэрийдлээр урсгал засварт 45193,0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь МУ-ын Тусгай сангийн тухай хуулийн 12.2 дугаар зүйлийн 12.2.1-12.2.8 дахь заалтууд, ЗГ-ын 2014 оны 2-р сарын 14-ний өдрийн 43 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийг бүхэлд нь зөрчсөн байна.

Дээрх байдлаас үзэхэд сумын ИТХ-ын тэргүүлэгчид, төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн сангийн төлөөлөгч, байгаль орчны ажилтнуудын мэргэжлийн мэдлэг хангалтгүйгээс ” Байгаль хамгаалах сан” –гийн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, зарцуулаагүй байна.

Иймээс ” Байгаль хамгаалах сан”- г холбогдох хууль журмын дагуу байгуулж, хөрөнгийг төвлөрүүлэх, төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2.Хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, үлдэгдэл

2.1. Худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэх

2.2. Хөрөнгийн орлого зарлагыг үнэн зөв бүртгэсэн эсэх

Хүдэр сумын ЭМТ нь 2014 онд 13343,0 мянган төгрөгийн түлээний модыг худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй байгаа нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1²⁷, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь²⁸ заалтыг зөрчсөн байна.

ЭМТ-д 2013 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 4181,8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий гадна цэвэр, бохир усны шугамын засвар хийгдсэн бөгөөд үндсэн хөрөнгийн бүртгэлд капиталжуулан бүртгэсэн байна. Мөн тайлант онд “Эрдэс холдинг” ХХК-ын хандив тусламжаар 10000,0 мянган төгрөгийн эхо аппарат, “Тогтвортой амьжиргаа-2” төслийн санхүүжилтээр 3980,0 мянган төгрөгийн цахилгаан хэрэгсэл болон эд хогшил, 2014 онд сумын БХС-гийн санхүүжилтээр 3600,0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авч бүртгэлд үнэн зөв тусгасан байлаа.

Тус ЭМТ-ийн эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 758,0 мянган төгрөгийн мал бодитой оршин байхгүй байхад балансад тусгасан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 4.1.2²⁹, 9.1³⁰ дэх заалтуудыг зөрчсөн байна.

Эмнэлгийн эрхлэгчийн тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогыг жил бүр хийж хэвшсэн боловч бараа материалын тооллогыг хийгээгүй байлаа.

Сургууль нь 2013 онд 350,0 мянган төгрөгийн ном худалдан авч, аймгийн БСГ-аас 11460,4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 165,9 мянган төгрөгийн тавилга, хэрэгсэл, 1762,2 мянган төгрөгийн ном зэрэг нийт 13388,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэлд бүрэн тусгасан байна. Тус сургууль нь 2014 онд БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 6044,6 мянган төгрөгийн ном, тавилга хэрэгсэл, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 14562,5 мянган төгрөгийн авто машин, аймгийн БСГ-аас 3511,3 мянган төгрөгийн ном, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 4056,1 мянган төгрөгийн дуу хөгжмийн техник хэрэгсэл, 2761,0 мянган төгрөгийн камерийн тоног төхөөрөмж зэрэг нийт 30935,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар хүлээн авч, бүртгэлд бүрэн тусгасан байна.

²⁷ Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

²⁸ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10 сая төгрөг

²⁹ санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх

³⁰ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

Цэцэрлэг нь 2014 онд Боловсролын яамнаас 11915,3 мянган төгрөгийн, аймгийн БГ-аас 5599,9 мянган төгрөгийн, эцэг эхийн хандиваар 1760,0 мянган төгрөгийн нийт 19275,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч бүртгэлд бүрэн тусгасан байна.

Бараа материалын худалдан авалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн босго үнэд хүрээгүй тул шууд худалдан авалтын аргыг сонгож, орлогод аван бүртгэлд үнэн зөвөөр тусгаж ирсэн байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн орлого, зарлага, үлдэгдлийн хэмжээ данс бүртгэлтэй тохирч, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэсэн байлаа.

Сумын төсөвт байгууллагууд нь материалын дэлгэрэнгүй тайланг сар бүр гаргаж, бараа материалыг УСНББОУС-ын дагуу үнэлж, тайлагнах, эргэлтийн хөрөнгийн биет тооллогыг улирал бүр зохион байгуулж, зардалд тавих хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

3.1. Татварын орлогыг бодитой төлөвлөсөн эсэх

3.2. Татварын орлогоо бүрэн төвлөрүүлсэн эсэх

Хүдэр сумын төсвийн орлогод 2013 онд 168862,4 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 173829,3 мянган төгрөг төвлөрүүлсэн бол 2014 онд 310111,1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 382692,9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Орлогын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 5 /мянган төгрөг/

	ОН	АНГИЛАЛ	ТӨСВИЙН ТӨСӨЛ	БАТЛАГД САН ТӨСӨВ	ТОДОТГО СОН ТӨСӨВ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
Төсвийн орлого	2013 он	Татварын орлого	76400,0	96759,0	127683,5	127626,4	57,1
		Татварын бус орлого	8500,0		41178,9	46202,9	-5024,0
	2014 он	Татварын орлого	82890,0	102667,0	270111,1	359562,3	-89451,2
		Татварын бус орлого	4000,0	40000,0	40000,0	23130,6	16869,4
Нийт дүн	2013 он	Нийт орлого	84900,0	96759,0	168862,4	173829,3	-4966,9
	2014 он	Нийт орлого	86890,0	142667,0	310111,1	382692,9	-72581,8

2013 онд улсын тэмдэгтийн хураамжийн орлого 146,0 хувиар, нэр заагдаж ангилагдаагүй бусад орлого 83,0 хувиар, 2014 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 12,0 хувиар, байгалийн ургамал ашигласны төлбөр 52,0 хувиар тус тус давж биелэсэн нь гүйцэтгэл өндөр гарахад гол нөлөө үзүүлжээ.

Тайлант онуудад сумын татварын орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийг авч үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

❖ 2013 онд 173829,3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан ч төсвийн төслийг 84900,0 мянган төгрөгөөр, 2014 онд 382692,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан ч төсвийн төслийг 86890,0 мянган төгрөгөөр төлөвлөж, тус тус үндэслэлгүй санал боловсруулсан нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” болон тухайн жилүүдийн төсвийн хүрээний мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

❖ 2014 онд ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн 2604,0 мянган төгрөгийг Ойн ангийн арилжааны банк дахь дансанд төвлөрүүлэн зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23.8.7³¹ дахь заалтыг зөрчсөн байна.

❖ 2014 онд хууль бусаар бэлтгэсэн модыг хураан авч, дуудлага худалдаагаар борлуулсны орлогын 8200,0 мянган төгрөгийг Ойн ангийн арилжааны банкин дахь дансанд төвлөрүүлэн зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23.9.2³² дахь заалтыг зөрчсөн байна.

Цаашид сумын төсвийн орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөж төвлөрүүлэх, давсан орлогыг тодотгох нэрийдлээр үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулалт гаргаж буй зөрчлийг арилгах шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хүдэр сумын төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа туйлын хангалтгүйгээс төр, төсвийн байгууллагуудад цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулах, тайлагнагдаагүй өр төлбөр барагдуулах, цалингийн сангийн хэмнэлтээс урамшуулал давхардуулан олгох, шатахуун, бичиг хэргийн зардлыг ажилтнуудын дансанд шилжүүлэх, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчил их хэмжээгээр оршиж байна.

1. Төсөвт байгууллагууд батлагдсан цалингийн зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.

³¹ ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрөөс бүрдэнэ

³² Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү торгуулийн орлого

2. Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй байна.
3. Тайлагнагдаагүй өр төлбөрийг тайлант оны цалингийн зардлаас барагдуулсан байна.
4. Төсөвт байгууллагууд шатахуун зарцуулалтын тайлан, жолоочийн замын хуудас зэрэг анхан шатны баримтуудыг хөтлөөгүй байна.
5. Эмнэлэг нь түлшний мод, эмийн тайлан гаргаагүй байна.
6. Шатахуун, бичиг хэргийн зардлын ажилтнуудын харилцах дансанд шилжүүлсэн байна.
7. Төсвийн орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй байна.
8. Байгаль орчны санг журмын дагуу байгуулж, зарцуулаагүй байна.
9. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг хугацаанд нь барагдуулаагүй байна.
10. Төрийн сангийн хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчил

Эрсдэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлбөрийн акт

ЭМТ

- Нягтлан бодогч Ж.Эрдэнэчимэг нь хуурамч баримт бүрдүүлэн хувьдаа завшсан 1658,6 мянган төгрөгийн,

Цэцэрлэг

- Үр дүнгийн урамшууллыг тогтоосон хувь хэмжээнээс илүү олгосон 603,8 мянган төгрөгийн,

Баг

- 2014 онд 1-р багийн Засаг дарга Ц.Цэнбумаа нь өөртөө болон 2-р багийн Засаг дарга Т.Эрдэнэбатад тушаал гарган урамшуулал авсан нийт 300,0 мянган төгрөгийн

Сургууль

- 2013 онд жижүүр Ж.Энхдалайд олгосон цалингийн урьдчилгааг буцаан суутгаагүй 260,0 мянган төгрөгийн зэрэг нийт **2822,4** мянган төгрөгийн

Албан шаардлага

ИТХ

- 2013 онд урсгал засварын зардлаас 500,0 мянган төгрөгийг дарга Р.Цогбадрахын, шатахууны зардлаас 60,0 мянган төгрөгийг ИТХ-ын төлөөлөгч С.Эрдэнэбатын, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 90,0 мянган төгрөгийг хэсгийн төлөөлөгч Н.Эрдэнэбатын хувийн харилцах данс руу шилжүүлэн зарцуулсан нийт 650,0 мянган төгрөгийн ,
- ИТХ-ын дарга Р.Цогбадрах нь 2013 онд өөртөө тушаал гарган үр дүнгийн урамшуулал авсан 150,0 мянган төгрөгийн,

- Төлөөлөгчдийг Улаанбаатар хотод “Нутгийн удирдлагын холбоо”-ны сургалтанд хамруулан 2013 онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 4022,1 мянган төгрөгийг, 2014 онд төлбөр хураамжийн зардлаас 5000,0 мянган төгрөгийг нийт 9022,1 мянган төгрөгийг зарцуулсан,
- 2013 онд шатахууны зардлыг анхан шатны баримтгүйгээр бүртгэл тайланд тусгасан 1011,0 мянган төгрөгийн зэрэг **нийт 10833,1 мянган төгрөгийн**

ЗДТГ

- 2013 онд цалингийн зардлаас үр дүнгийн урамшуулалд 658,6 мянган төгрөгийг, шатахууны зардалд 891,8 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нийт 1550,4 мянган төгрөгийн,
- 2013 онд халаалтын зардлаас 123,0 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны зардлаас 91,0 мянган төгрөгийн, цэвэр бохир усны зардлаас 120,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нийт 334,0 мянган төгрөгийн,
- 2013 онд шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 9000,0 мянган төгрөгийн,
- 2013 онд шатахууны зардлаас жолооч А.Хүдэрхуягийн хувийн харилцах дансанд шилжүүлэн зарцуулсан 345,5 мянган төгрөгийн,
- 2013 онд шатахууны зардлыг анхан шатны баримтгүйгээр бүртгэл тайланд тусгасан 3882,6 мянган төгрөгийн,
- 2014 онд цалингийн зардлаас урьд оны ХХОАТ-ын өр төлбөрт 4411,1 мянган төгрөгийг, НД-ын байгууллагаас тогтоосон актын төлбөрт 801,1 мянган төгрөгийг, ажилтан Цэнгэлмаа, Энхбаяр нарын сургалтын төлбөрт 533,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нийт 5745,2 мянган төгрөгийн,
- 2014 онд гэрэл цахилгааны зардлаас халаалтын зардалд 404,1 мянган төгрөгийг, цэвэр бохир усны зардлаас гэрэл цахилгааны зардалд 224,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан, мөн гэрэл цахилгааны зардлаас 110,3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нийт 738,4 мянган төгрөгийн зэрэг **нийт 21596,1 мянган төгрөгийн**

Баг

- 2014 онд бичиг хэргийн зардлаас 245,7 мянган төгрөгийг 2-р багийн Засаг дарга Т.Эрдэнэбатын, төлбөр хураамжийн зардлаас 70,0 мянган төгрөгийг 1-р багийн Засаг дарга Ц.Цэнбумаагийн хувийн харилцах дансанд шилжүүлэн зарцуулсан нийт 315,7 мянган төгрөгийн,
- 2013 онд шатахууны зардлыг анхан шатны баримтгүйгээр бүртгэл тайланд тусгасан 356,1 мянган төгрөгийн,
- 2013 онд 1-р багийн Засаг дарга Ц.Цэнбумаагийн Сэлэнгэ аймагт ажилласан томилолтын зардлыг тавилга эд хогшлын зардлаас гаргасан 16,0 мянган төгрөгийн зэрэг **нийт 687,8 мянган төгрөгийн**

БХС

- “Байгаль хамгаалах сан”-гийн хөрөнгийг сумын төсвийн байгууллагуудын урсгал засвар, тохижилтонд зориулалт бусаар зарцуулсан **45193,0 мянган төгрөгийн,**

ЭМТ

- 2014 онд цалингийн зардлаас эмийн зардалд 1286,9 мянган төгрөгийг, магадлан итгэмжлэлийн төлбөрт 450,0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй нийт 1736,9 мянган төгрөгийн,
- 2014 онд халаалтын зардлаас зөвшөөрөл авалгүйгээр гэрэл цахилгааны зардалд гүйлгэн зарцуулсан 907,6 мянган төгрөгийн,
- Эмч, сувилагч нарт тушаал шийдвэргүйгээр сар бүр 10 хувиар тооцож, ур чадварын нэмэгдэл олгосон 2013 онд 4246,0 мянган төгрөгийн, 2014 онд 2017,7 мянган төгрөгийн нийт 6263,7 мянган төгрөгийн,
- Мөн эмч, сувилагч нарт сар бүр хүнд өвчтөн асарсан, сургалт зохион байгуулсан нэрийдлээр 10 хувийн нэмэгдлийг хавтгайруулан тушаал шийдвэр болон дэмжих баримтгүйгээр олгосон 2013 онд 3885,0 мянган төгрөгийн, 2014 онд 3307,6 мянган төгрөгийн нийт 7192,6 мянган төгрөгийн,
- Тайлант онуудад эрхлэгч Г.Нармандах нь сумын Засаг даргаар ажлаа дүгнүүлэлгүйгээр, өөрөө өөртөө тушаал гарган үр дүнгийн урамшуулал авсан 1514,2 мянган төгрөгийн,
- Нягтлан бодогч, нярав, жижүүр, слесарь зэрэг 5 хүний үр дүнгийн урамшууллыг буруу тооцож, дутуу олгосон 2013 онд 868,5 мянган төгрөгийн, 2014 онд 1090,0 мянган төгрөгийн нийт 1958,5 мянган төгрөгийн,
- Эрсдлийн аудитын явцад цалингаас суутгасан ХХОАТ-ыг татварын тайлантай тулган баталгаажуулахад санхүүгийн тайлан болон татварын тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэнээс цалингийн санг 9927,4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж, ХХОАТ-ын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй 666,8 мянган төгрөгийн,
- 2014 онд түлээний модны бэлтгэн нийлүүлэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй 13343,0 мянган төгрөгийн,
- Эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй мал бодитоор оршоогүй байхад балансад тусгасан 758,0 мянган төгрөгийн,
- 2014 оны жилийн эцэст 5 машин түлээний модыг балансад үлдэгдлээр тайлагнаагүй 741,0 мянган төгрөгийн,
- Эмийн дэлгэрэнгүй тайлан гаргаагүй, эмийн тооллогыг улирал бүр хийгээгүй зэрэг нийт **35082,3 мянган төгрөгийн,**

Цэцэрлэг

- 2014 онд цалингийн зардлаас үр дүнгийн урамшуулалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 3927,6 мянган төгрөгийн,
- 2014 онд цалингийн зардлаас урьд оны НДШ-ийн өр төлбөрт гүйлгэн зарцуулсан 4175,0 мянган төгрөгийн,

- 2014 онд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нэмэгдэл цалин олгосон 722,5 мянган төгрөгийн,
- 2014 онд тушаал шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал олгосон 607,6 мянган төгрөгийн,
- 2014 онд шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 1351,6 мянган төгрөгийн зэрэг **нийт 10784,3 мянган төгрөгийн**

Сүргүүл

- Багш, ажиллагсдад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нэмэгдэл цалин олгосон 2013 онд 923,7 мянган төгрөгийн, 2014 онд 1601,2 мянган төгрөгийн нийт 2524,9 мянган төгрөгийн,
- 2013 онд төсөвт сууж батлагдаагүй бүжгийн багшийг гэрээгээр 1 сарын хугацаатай ажиллуулан 502,2 мянган төгрөгийн цалин олгосон,
- Шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 2013 онд 3310,0 мянган төгрөгийн, 2014 онд 3152,9 мянган төгрөгийн нийт 6462,9 мянган төгрөгийн,
- 2014 онд онд гэрэл, цахилгааны зардлаас халаалтын зардалд 64,5 мянган төгрөгийг, халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 236,1 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нийт 300,6 мянган төгрөгийн,
- НДШ-ийн зардлаас 2014 онд 1019,4 мянган төгрөгийг цалингийн зардалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зэрэг **нийт 10810,0 мянган төгрөгийн**

Ойн анги

- 2014 онд төсөв хэтрүүлэн зарцуулсан 274,5 мянган төгрөгийн,
- Хууль бусаар бэлтгэсэн модыг хураан авч дуудлага худалдаагаар борлуулсны орлогыг 2014 онд Ойн ангийн арилжааны банкин дахь дансанд төвлөрүүлэн зарцуулсан 8200.0 мянган төгрөгийн,
- 2014 онд ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг Ойн ангийн арилжааны банк дахь дансанд төвлөрүүлэн зарцуулсан 2604.0 мянган төгрөгийн,
- Ойн ангийн нягтлан бодогч Ш.Урнаа нь 2014 онд бэлэн мөнгөний хүсэлт бичин өөрөө цохолт хийж авсан нийт 537,0 мянган төгрөгийн зэрэг **нийт 11615,5 мянган төгрөгийн**

Хүдэр сумын төр, төсвийн байгууллагуудад нийт 149424,5 мянган төгрөгийн зөрчил илэрч 2822,4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 146602,1 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

1. ЗАСАГ ДАРГА Б.НАРАНЦЭЦЭГ-Т

- Сумын төсвийн орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх.
- Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх
- Төсвийг зохистой удирдаж өглөг, авлага үүсгэхгүй ажиллах.
- ЭМТ-ийн эрхлэгчийн ажлыг журамд заасны дагуу үнэлж, дүгнэж байх.
- Байгаль хамгаалах санг журмын дагуу байгуулж, төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах
- Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлж барагдуулах, барьцаа хөрөнгийг гэрээний дагуу борлуулж санг хохиролгүй болгох.
- Их хэмжээний санхүүгийн зөрчил гаргасан ЭМТ-ийн эрхлэгчид холбогдох хууль эрхийн актын хүрээнд хариуцлага тооцох, хуурамч баримт бүрдүүлэн төсвийн хөрөнгийг хувьдаа ашигласан нягтлан бодогчийг үүрэгт ажлаас чөлөөлөх.
- Удаа дараагийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, байнгын их хэмжээний зөрчил гарган, төрийн сангийн хяналтын үйл ажиллагааг хангалтгүй гүйцэтгэж буй төрийн сангийн төлөөлөгч Т.Түмэндэлгэрт холбогдох хууль эрхийн актын дагуу хариуцлага тооцох.

2. ТӨРИЙН САНГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ Т.ТҮМЭНДЭЛГЭР-Т

- Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.
- Цалингийн зардлыг бусад зардлын зүйлд гүйлгэн зарцуулахгүй байх.
- “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг баримталж ажиллах.
- Аймгийн Аудитын газраас удаа дараагийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, төрийн сангийн хяналтын үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх,

3. БАЙГУУЛЛАГУУДЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР, НЯГТЛАН БОДОГЧ НАРТ:

- Төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөж, баталгаажуулан санхүүгийн баримтанд хавсаргаж байх.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.
- Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнаж байх.
- Цалингийн нэмэгдлийг хууль, тогтоомжийн дагуу олгож байх.

- Эрүүл мэнд, боловсролын байгууллагын ажилтнуудын ажлын үр дүнтэй уялдуулан тогтоосон хувь хэмжжний хүрээнд урамшуулал олгох, урамшуулал, нэмэгдлийг давхардуулан олгохгүй байх.
- Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, зайлшгүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас журмын дагуу зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх.
- Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг данс бүртгэлд тусгахгүй байх.
- Эм, шатахуун, түлээний модны зарцуулалтын тайлан гаргаж байх.
- Жил бүр эд хөрөнгийн тооллого явуулж байх.
- Өмч хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

Ц.ОТГОНБАЯР

ШИНЖЭЭЧ

С.БААСАНСҮРЭН

Э.ЭРДЭНЭЗУЛ

А.ДАШБАТ